# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ГЭЛЭГЖАМЦЫН ЭНХТАЙВАНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах | | | | | | | |
| 1 | 1.1.Дэлхийн худалдааны байгууллагын "Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангахтай холбоотой Монгол Улсын авсан үүрэг амлалтыг биелүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагаас Монгол Улсын Худалдааны бодлогыг хянасан 2023 оны дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр | Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хүргүүлж 2023 онд 85.3 хувьд хүрсэн. 3.ГЕГ-ын 2021 онд худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2023 онд хэрэгжилт хангах үүрэг амлалт авсан арга | 1.Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн "7 дугаар зүйлийн 5 дахь заалт Бүрдүүлэлтийн дараах шалгалт-ын биелэлтийг хүргүүлсэн байна. Барааны урьдчилсан шийдвэртэй холбоотой биелэлтийг хүргүүлнэ. Нийт | ДГБ, НҮБ-ын ХХБХ, АХБ, КАРЕК, Олон улсын валютын сан, Олон улсын худалдааны төв, ГХЯ, ЭЗХЯ болон ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороод, худалдаа эрхлэгчидтэй албан бичиг, цахим захидал солилцох, уулзалт, сургалт зохион байгуулах, оролцох чиглэлээр хамтран ажилласан.<br>ГЕГ-ын Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсэг (ХХАХ)-ийг бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлттэй уялдуулан өөрчилж, 2024 оны ажлын хэсгийн төлөвлөгөөг батлуулж, ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн. Мөн ЗББНДБ-уудын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулахаар Уул уурхайн бус тэргүүлэх салбарын 2024-2028 Үндэсний экспортын стратегийг ЗДАС-ийн Худалдааг хөнгөвчлөх талбарт оруулсан. НҮБ-ын ХХБХ-тай 3 удаа цахим уулзалт хийж, 14 цахим захидал солилцсон. НҮБ-ын ХХБХ-ын | 2024.01.01 - 2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээний тайлан хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажилласан. | хэрэгжилт 94 хувьтай байна.<br>2.Монгол Улсын Худалдааг Хөнгөвчлөх Үндэсний Хороонд Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 2 заалт (7.4. Эрсдэлийн удирдлага, 10.3. Олон улсын стандарт ашиглах)-ын биелэлтийг хүргүүлсэн байна. Нийт хэрэгжилт 73 хувьтай (67.4+5.6) байна.<br>3.Монгол Улсын Худалдааны бодлогыг дүгнэсэн 2021 оны тайлангийн хэрэгжилтийг хангасан байна. | Монголын гаалийн зарим үйл ажиллагааг цахимжуулах хөтөлбөрийн хүрээнд Олон улсын шуудан илгээмжийн байгууллагын гишүүн орнуудтай УХШИ-ийн мэдээлэл урьдчилан авах үйл ажиллагааг цахимжуулах туршилтын тест хийх боломжийг хангахаар ГБ-ын мэдээллийн технологийн дэд бүтэц, сүлжээний хурд, боомтын өдрийн дундаж хяналтын мэдээллийг 2022, 2023 оны байдлаар гаргаж өгсөн. Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо (ХХҮХ)-нд ГЕГ-ын ХХАХ-ийн 2024 оны төлөвлөгөө, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргүүлсэн. ДГБ-ын "Меркатор" хөтөлбөр болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чадавхыг бэхжүүлэх онош зүйн шинжилгээний тайланг хүргүүлэх арга хэмжээг ГЕГ-ын ХХАХ-ийн төлөвлөгөөнд тусгасан. 2024 оны эхээс эрсдэлийн удирдлагад суурилсан БДШ-ыг зохион байгуулсан. БДШ-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийг ГХЯ-нд цахимаар хүргүүлсэн. ЗББНДБ, ГГХ-дыг мэдээллээр хангасан. ДГБ, НҮБ-ын ХХБХ, АХБ, КАРЕК, Олон улсын валютын сан, Олон улсын худалдааны төв, ГХЯ, ЭЗХЯ болон ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороод, худалдаа эрхлэгчидтэй 9 албан бичиг, 53 цахим захидал солилцож, 15 уулзалт, 5 сургалтад оролцож, 1 сургалт зохион байгуулж, хамтран ажилласан: ХХАХ-ийг шинээр байгуулж, ХХҮХороотой хамтран ажиллаж, 29 мэдээ, тайлан, судалгаа болон бусад бодлогын баримт бичгийг ГЗДАС-ийн "Худалдааг хөнгөвчлөх" дэд талбарт байршуулж, давхардсан тоогоор 1,439 албан хаагч хандаж, мэдээлэл авсан. Их түмэн санаачилгатай "Аж үйлдвэрийн парк бодлогын хэлэлцүүлэг; Зүүн, хойд Азийн Худалдааг хөнгөвчлөх олон улсын семинар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулах; Бизнесийн нийгэмлэгтэй хамтран ажиллах" гэсэн чиглэлээр хамтран ажиллах боломж бүрдсэн.<br>-"ДГБ-Швейцарийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Байгууллагын хамтарсан Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр" -т Монголын Гаалийн байгууллага 2024-2027 онд онд хамрагдахаар болсон. Үүнтэй уялдуулан Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөрийн Хоёрдугаар шатны зорилго, зорилт; Гаалийн байгууллагын тэргүүлэх чиглэл, хүлээлтийн талаар танилцуулга хэрхэн бэлтгэх талаар ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодыг мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангасан.<br>-УХШИ-ийн мэдээллийг урьдчилан солилцож, гаалийн бүрдүүлэлтэд ашиглах техник технологийн чадамжын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон.<br>-ХХҮХороог мэдээллээр хангасан.<br>-ГХЯ-ыг мэдээллээр хангасан.<br>ХХХ-ийн хэрэгжилтийг 85.3-аас 87 хувьд хүргэсэн. | | |
| 2 | 1.2.Гадаад орны гаалийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд гадаад худалдааны мэдээлэл солилцох үйл ажиллагааг хөгжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | БНХАУ-ын 5 боомтын зэрэгцүүлэлтийг хийсэн.<br>4.ОХУ-ын зүгээс биечлэн зэрэгцүүлэлт хийх боломжгүй гэх хариуг ирүүлсэн. | 1.БНХАУ-тай 2023 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийсэн байна.<br>2.ОХУ-тай 2023 оны гадаад худалдааны статистик зэрэгцүүлэлт хийсэн байна. | 2024 оны хамтарсан шалгалт, холбоо баригч дарга нарын уулзалтыг БНХАУ-ын ГЕГ, ОХУ-ын ХГА-аас зохион байгуулах ээлжтэй тул зохион байгуулагч талаас уулзалт товлох хугацааг хүлээж байна.Дээрх чиглэлээр 2023 онд зохион байгуулагдсан уулзалтуудын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд биелэлт дундажаар 86 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>БНХАУ-ын ГЕГ-аас 2024 оны хамтарсан шалгалтын уулзалтын бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2024.06.05-ны өдөр майлээр "Хяналт, шалгалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх" төслийг ирүүлсэн. Иймд дээрх төсөлтэй танилцаж саналаа 2024.06.10-ны өдрийн 231 дугаартай дотоод зурвасаар | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | БНХАУ-ын ГЕГ-т хүргүүлэхээр ГХАХ-т хүргүүлсэн.<br>ОХУ-ын ХГА-аас 2024.04.19-ний өдөр “Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын рентген тоног төхөөрөмж ашиглан мэдээлэл солилцох тухай хэлэлцээр”-ийг шинэчлэх төсөл ирүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа боомтын шинэчлэлтэй уялдуулан “Гаалийн хяналтын үр дүнг сайжруулах зорилгоор рентген төхөөрөмж ашиглан авсан мэдээллийг солилцох тухай” Монгол Улсын ГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын Уфа хотноо 2015.07.09-ний өдөр байгуулсан хэлэлцээрийг шинэчлэх шаардлагатай болсон. | | |
| 3 | 1.3.Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох | Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | Гаалийн байгууллага эрсдэлийн дүн шинжилгээ хийж, хууль сахилтын түвшингээр үнэлж, 593 эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулж, программд оруулсан. Нийт 1416 эрсдэлийн шалгуурын үр дүнд тухайн шалгуурт баригдсан гаалийн бүрдүүлэлтийн бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдөх хувь хэмжээ экспортын гаалийн бүрдүүлэлтийн хувьд 22.7 хувиар, | 1.Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг 30 хувиар нэмэгдүүлнэ.<br>2.Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг 65 хувьд хүргэнэ.<br>3.Аж ахуйн нэгж өөрийн хууль сахилтыг өөрөө үнэлдэг, гаалийн байгууллагатай хууль сахилтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.<br>4.Төмөр зам болон авто замын | Эрсдэлийн профайл, шалгалтын үр дүнгийн санал, ГЕГ-ын ЗББНДБ-аас ирүүлсэн санал, тус хэлтсээс хийсэн судалгааны үр дүнд үндэслэн тайлант хугацаанд 282 ААН, 222 барааг эрсдэлийн мэдээллийн санд оруулж, баяжилт хийсэн.<br>Зорчигч:Агаарын тээврээр зорчсон 651,753 зорчигчийн мэдээллийг урьдчилан авсан. Эдгээрийг эрсдэлийн мэдээллийн сан болон бусад эх сурвалжийн мэдээлэлтэй харьцуулж, 1,540 зорчигчийг онилсон. ШҮД-ийн саналаас харахад бусад 71.6%, зөрчилгүй 26%, 2.4% нь захиргааны зөрчил илэрсэн, гаалийн бүрдүүлэлтийн хуудас бичсэн, саатуулсан, эрсдэлтэй байж болзошгүй гэсэн тайлбар тус тус ээлжээ. “Эрсдэлтэй зорчигчийн мэдээллийн сан”-ын ШҮД-ийн санал болон бусад эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн эрсдэлтэй байх магадлалтай 70 зорчигчийн мэдээллээр баяжуулсан.<br>“Бэлэн мөнгөний хяналт” талбарт зорчигчийн бэлэн мөнгөний мэдээллийн жагсаалтыг 21 улсын 4,331 зорчигчийн 17 үзүүлэлтээр нийт 75,237 өгөгдлөөр баяжуулсан байна. | 2024.01.01 - 2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | импортын гаалийн бүрдүүлэлтийн хувьд 9 хувиар нийт гаалийн бүрдүүлэлтэд бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 15.45%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>3.Гадаад худалдаа эрхлэгчийн хууль сахилтын түвшинг тодорхойлох загварыг боловсруулж, Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмын төсөлд оруулсан.<br>4.Зорчигчийн мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцож ажиллаж байна. Эрсдэлийн мэдээллийн санд 2023.11.30-аар 247 эрсдэлтэй зорчигч, 2022 онд 218 эрсдэлтэй зорчигч тус тус бүртгэгдсэн. Бүртгэсэн эрсдэлтэй зорчигчийн тоо нь | тээврээр зорчих зорчигчийн мэдээллийг ашиглан эрсдэл тооцох боломжийг бүрдүүлэхийн тулд “Эрсдэлтэй зорчигчийг онилох систем”-ийн хөгжүүлэлтийг хийсэн байна. | Хяналтын төлөвийн хэрэгжилт: Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт мэдүүлгийн 63.1%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 3.5%-иар өссөн статистик үзүүлэлттэй байна.<br>Төлөв солилт, засварт буцаалт: Нийт 1,294 гаалийн мэдүүлгийг засварт буцаасан нь нийт бүрдүүлэлтийн 0.3%-ийг эзэлж, 717 мэдүүлгийг “баталгаажихаас өмнө”, 577 мэдүүлгийг “баталгаажуулсны дараа” тус тус засварт буцаасан байна. Өнгөрсөн оны үеэс 6 дахин буурсан байна.<br>2. Системийн хэмжээнд ЭУ-д суурилсан ГХ-ын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор макро түвшний 7, микро түвшний 19 судалгааг хийж гүйцэтгэсэн.<br>3. ЭУ-ын программын мэдээллийн санд 9 профайл, 95 хяналтын хуудсаар 483 шалгуур үзүүлэлтийг боловсруулж, оруулан ЭУ-д суурилсан ГХ-ыг хэрэгжүүлж ажилласан.<br>4. ЭУ-д суурилсан ГХ-ын үр дүнг үндэслэн БДШ-д хамруулахаар “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”, “Шалгалтын үр дүнгийн санал”, Зөрчилд холбогдсон байдал”, “Эрсдэлийн дүн шинжилгээний үр дүн” зэргийг үндэслэн 6 удаагийн удаагийн дотоод зурвасаар 302 ААН-ийн жагсаалтыг хүргүүлсэн.<br>Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журмын дагуу Маягт1; 2-ыг авч үзэхэд Маягт1-ын 4,642 бүрдүүлэлт хийсийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.54 дахин өссөн. Маягт2-аар 10,613 бүрдүүлэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.65 дахин өссөн. Эдгээр ажлуудын үр дүнд **<u>Хүрсэн үр дүн:</u>** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.7 хувиар өссөн. Эрсдэлийн мэдээллийн санд гаалийн байгууллага эрсдэл тооцсоны үр дүнгээр 78.9%, бусад байгууллагын 21.1%-ийн мэдээллийн эх сурвалжид үндэслэн бүртгэсэн байна. Одоогоор төмөр зам болон авто замын тээврээр зорчих зорчигчийн мэдээлэлд эрсдэл тооцох боломж бүрдээгүй байна. | | 1.Эрсдэлийн мэдээллийн санд шалгуур оруулж, баяжилт хийсэн байдал нь өнгөрсөн оны мөн үеэс 5 шалгуураар өссөн байна.<br>Зорчигчийн эрсдэлийн мэдээллийн сангийн ШҮД-ийн саналаас харахад бусад 71.6%, зөрчилгүй 26%, 2.4% нь захиргааны зөрчил илэрсэн, ГБ-ийн хуудас бичсэн, саатуулсан тайлбар тус тус ээлсэн. Орох чиглэлийн 864 зорчигчийн мэдээллийг хянаж үзэхэд Алт, монет, үнэт эдлэл улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх магадлалтай зорчигч хамгийн олон давтамжтай онилогдсон. Мөн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг болон зөөвөрлөх магадлалтай зорчигч тус тус онилогдсон ба зорчигчдоос хар, тамхи мансууруулах бодис илрээгүй. Харин мэдээлэлтэй нэг зорчигчийг онилж, Эрүүгийн цагдаагийн албатай хамтран шалгаж, ЦБ-д шилжүүлсэн.<br>Агаарын тээврээр зорчсон эрсдэлтэй зорчигчийн сангийн мэдээллээр онилогдсон зорчигчдын дагалдах ачаандаа авч явсан бараанд 14 гаалийн бүрдүүлэлт хийж, 6.3 сая төгрөгийн гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлж, 2 ачааг гаалийн бүрдүүлэлт хийлгэхээр саатуулсан.<br>Зорчигчийн арилжааны шинжтэй барааны бүрдүүлэлт (Маягт № 1; 2)-д ногдуулж, хураасан гаалийн болон бусад татварын дүн 2 дахин нэмэгдсэн.<br>Зорчигчийн бэлэн мөнгө мэдүүлсэн байдалд дүн шинжилгээ хийхэд 17 валютаар мэдүүлсэн байна. Үүнээс хамгийн их буюу 86.7% рубль (255.43 сая), 5.9% ам. доллар (13.4 сая), 2.9% юань (14.6 сая), үлдсэн 4.5% бусад 14 улсын валют эзэлжээ. Үүнийг 2023 онтой харьцуулахад 14 улсын валютаар мэдүүлснээс 84.2% рубль (508.2 сая), 8.9% ам.доллар (6.9 сая), 2.8% юань, үлдсэн 4.1% бусад 11 улсын валют эзэлжээ. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2.Судалгааны үр дүн:Улсын төсвийн орлогоос зайлсхийх эрсдэлт орчныг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор ЗҮГГ-т ААН, иргэдийн ГБ-д хийх үйл ажиллагааг итгэмжлэл олгон, төлөөлөгчөөр дамжуулан хийж буй ГБ-д дүн шинжилгээ хийж, 259 ААН-ийн жагсаалтыг БДШГ-т хүргүүлсэн. Үүнээс 20 ААН-д 2024.06.20 байдлаар БДШ хийх удирдамж батлагдаж, шалгалт орсон. 12ААН бүрэн дуусч 9-д зөрчил илэрсэн.<br>Япон Улсаас БТКУС-ийн 8703 зүйлийн түвшинд суудлын машин импортлох иргэдийн судалгааны үр дүнд эрсдэлийн ШҮ боловсруулж, ЭУ-ын программд оруулж, ГБ-д зарцуулах цаг хугацааг бууруулсан.<br>3.Стратегийн түвшний өндөр эрсдэл бүхий эк, им-ын бүрд-тэй холбоотой шалгуур үзүүлэлтийг тухай бүр боловсруулан, баяжилт, анхааруулгын хамт ор-ж, эрсдэлийг бууруулсан. ГХ-ны бараа эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14%-аар, төсвийн орлого 27%-аар өсөхөд нөлөөлсөн. | | |
| 4 | 1.4.Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа хийх арга зүйг боловсронгуй болгон, бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах үйл ажиллагааг зохион байгуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа, хувиар, Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | 1.2019 оны Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна. "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны | Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг хийж дуусгасан, тайлан гарсан байна. | 2023.10.24-ний өдөр баталсан удирдамжаар байгуулагдсан ажлын хэсэг "Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгаа"-г хийж, 2024.05.09-ний өдөр тайлангаа гаргалаа. Судалгаанд Бүрдүүлэлтийн цаг хугацааны өмнөх таван удаагийн судалгааны дүн, 2019, 2022, 2023 оны судалгаанд хамрагдсан 17,352 гаалийн мэдүүлэг, 100,152 барааны бичлэгт хамаарах, таван дэд программаас авсан давхардсан тоогоор 18 төрлийн 266,309 мянган өгөгдөл/мэдээллийг хамруулсан. Сонгож авсан хугацаанд гаалийн газар, гаалийн хяналтын бүсэд хийгдсэн бүрдүүлэлтийн мэдээллийг КАИС-ийн таван дэд програмаас татаж, харьцуулан, хилийн гаалийн байгууллага дээр, хилээс гүний | 2024.01.01 - 2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | судалгаа”-г 2023 онд хийсэн.<br>2.2019 онд хийгдсэн “Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах судалгаа”-ны дүнтэй 2023 онд хийсэн судалгааг харьцуулж байна. | | гаалийн байгууллагын хяналтад илгээж, барааг эзэнд нь олгох хүртэлх цаг хугацааг тооцоолон, өмнөх судалгаатай харьцуулж, цаг хугацааны өөрчлөлтийг гаргасан.<br>ГЕГ-ын 2019 оны Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаатай 2023 оны судалгааг сонгон авсан гаалийн газар, хороодоор харьцуулахад “Тээвэрлэлт, Татвар төлөх хугацаа, Хорио цээрийн шалгалт, Гаалийн лабораторийн шинжилгээ”-нд зарцуулсан хугацаа нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлжээ. Бүрдүүлэлтийн цаг хугацааны 2023 оны судалгааг 2019 оны судалгаатай харьцуулахад зөрүүтэй байгаа нь өгөгдөл/мэдээлэл цуглуулсан, боловсруулсан аргачлалын хувьд ялгаатай байгаатай холбоотой. Үүнтэй уялдуулан хоёр судалгааны ижил болон ялгаатай талыг харьцуулан харуулсан.<br>“Татвар төлөх хугацаа” нь бүрдүүлэлтийн цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн ба 2022 онд дунджаар 20 цаг, 19 минут, 2023 онд дунджаар 19 цаг 38 минут тус тус зарцуулсан. Мэдүүлэгч нар бараагаа хүлээж авахгүй цаг хугацаа алдаж байгаа нь улаан төлөвтэй мэдүүлэгт хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагч, улбар шар, ногоон төлөвтэй мэдүүлэгт хяналт, шалгалт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч дээр хуваарилагдсан цаг хугацааг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.<br>Мөн хяналтын улбар шар болон ногоон төлөвт сонгогдсон гаалийн бүрдүүлэлтийн хугацаа улаан төлөвтэй бараг ойролцоо гарсан нь “Татвар төлөх хугацаа” өндөр байгаатай холбоотой бөгөөд нэг болон олон нэр төрөлтэй бараа эсэхээс үл хамаарч бичиг баримт болон бараанд хийх шалгалтад ижил хугацаа, эсхүл нэг нэр төрлийн бараанд илүү хугацаа зарцуулсан байсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шинжилгээг голч утга (медиан)-аар авч үзэхэд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацаа 2023 онд 267.5 минут байгаа нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар өссөн бөгөөд үүнд хорио цээрийн шалгалтад 2023 онд зарцуулсан дундаж хугацаа болох 841 минут/14 цагийг 2022 оны мөн үетэй харьцуулахад 136 минут/16 хувиар өссөн нь нөлөөлжээ. Шинжилгээний үр дүнд "Хорио цээрийн шалгалт болон ГУАБ зөвшөөрөх" үе шат нь дундаж хугацаанаас хэт хазайлттай гарсан. Энэ нь тухайн үе шатанд тооцоолол хийхэд хүндрэл учруулах эрсдэлийг бий болгожээ. Бусад үе шатын хувьд 40-124 минут/0.7-2.06 цагаар буурсан байна.<br>Бүрдүүлэлтийн үе шат бүрээс бичиг баримтын шалгалтад зарцуулсан дундаж хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 124 минут буюу 2.77 дахин буурсан нь бичиг баримтын шалгалтыг нэг цэгт төвлөрүүлсэнтэй холбоотой. Энэхүү судалгааны шинжилгээг дундаж утгын хүрээнд авч гүйцэтгэхэд 2023 онд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулсан хугацааг 2022 оны мөн үетэй харьцуулахад 8 хувиар бууруулсан дүн гарсан. | | |
| 5 | 1.5.Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг олон улсын стандартын дагуу бүрэн хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд байгуулсан "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, Туршилт хийсэн болон шалгаруулсан аж ахуйн нэгжийн тоогоор | 1.ОХУ-тай гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах арга хэмжээний суурь тавигдсан.<br>2. ГЕГ-ын даргын 2021 оны А/118 тушаалаар батлагдсан "Худалдааг хөнгөвчлөх, | 1.Гаалийн итгэмжлэлийг гадаад худалдаанд оролцогчдын бусад төрлөөр олгох ажлыг зохион байгуулсан байна. "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулах орны тоог 1-2-оор нэмэгдүүлэх саналыг хүргэж, | 1. БНСУ, ОХУ-ын ГБ-тай тус бүр 1 удаа цахим уулзалт,<br>2.БНХАУ, БНСУ-ын ГБ-аас 3, Монгол Улсын ГБ-аас 1 ГИААН-ийн мэдээллийг цахимаар солилцсон.<br>3.Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC), Монгол Улсын ГБ хамтран ИААН хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинарыг Улаанбаатар хотноо 2024 оны 4 сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан. ГУБ болон хувийн хэвшлийн төлөөлөгчдийг хамруулж, 3 илтгэл тавьсан.<br>4.2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Их түмэн | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам"-ын дагуу "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" төрийн өмчийн үйлдвэрийн газарт үйл ажиллагаанд 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр "Гаалийн итгэмжлэл" олгосон. | бэлтгэл ажлыг хангасан байна.<br>2.Итгэмжлэгдсэн 1-2 аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна. | санаачилгын Гаалийн дэд хороо, Худалдаа хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдааныг зохион байгуулахад болон хуралдаануудад оролцож, "ИААН-ийг ХХЗХ-ийг хэрэгжүүлэх хэлэлцээрийн чадавхыг бэхжүүлэх" төслийг танилцуулсан.<br>-Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC), Монгол Улсын гаалийн байгуулага хамтран зохион байгуулсан ИААН-ийн хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинарт 3 сэдвээр илтгэл бэлтгэж, сургалтад оролцогчдод танилцуулж, брошюр тараасан. Монголын гааль цахим хуудсаар богино хэмжээний 11 бичлэг (7 reel, 4 video), ГБ-ын албан ёсны цахим хуудсаар 2 мэдээллийг тус тус олон нийтэд хүргүүлсэн.<br>-"Менежментийн форум-2024" арга хэмжээнд 2024.03.13-нд оролцож, бизнес эрхлэгчдэд "Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж" хөтөлбөрийн брошюр тарааж, Юнивишн, Юнител, Мобиком, Шангрила ХХК-ийн төлөөлөгчдөд хөтөлбөрийн талаар товч танилцуулж, зөвлөгөө өгсөн.<br>-УБГГ-аас албан бичгээр ирүүлсэн судалгаанд үндэслэж, Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК-д "ГИААН хөтөлбөр"-ийн тухай болон хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02-1/1534, 02-1/1535, 02-1/1536, 02-1/1537, 02-1/1538 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн. Говь ХК, Янмал ХХК-ийн менежерүүдэд биет уулзалтаар болон утсаар холбоо барьж өөрийн үнэлгээний хуудсыг хэрхэн нөхөн бичих талаар зөвлөгөө өгсөн. Үүний үр дүнд:<br>- Талууд ГИААН-ийн мэдээллийг харилцан солилцож, туршлагаа хуваалцсан. Хэлэлцээрийг туршилтаар хэрэгжүүлж, үр дүнд үндэслэж 2 талаас албан ёсоор хэрэгжүүлэх хугацааг товлохоор тохиролцсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Гаалийн байгууллагын болон хувийн хэвшлийн төлөөлөгчдөөс бүрдсэн 50 үндэсний сургагч багш бэлтгэгдсэн.<br>- ГИААН-үүдийн мэдээллийг МТГ-т цахимаар хүргүүлж, программд оруулсан.<br>- Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооноос 2024 оны 9 дүгээр сард УБ хотноо зохион байгуулагдах "Их түмэн санаачилга"-ын Зөвлөлдөх комисст танилцуулан, батлуулахаар шийдвэрлэсэн Энэхүү төсөл нь Гаалийн дэд хорооны 2024-2025 онд төлөвлөгөөндөө тусгасан ЗУРГААН ажлын төлөвлөгөөнд тусгагдсан.<br>- Сурталчилан таниулах ажлыг гүйцэтгэснээр 9000 орчим хүн тус хөтөлбөрийн талаар цахимаар мэдээлэл авсан байна. 5 ААН цаашид хөтөлбөрт хамрагдахаар ЭУХ болон УБГГ-тай хамтарч ажиллаж байна. | | |
| 6 | 1.6.Гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, дүрэм, журам, түүнийг зохицуулсан үйл ажиллагаа, гадаад худалдааны статистик мэдээллийг монгол, англи хэл дээр түгээх, гадаад худалдааны нэгдсэн портал бий болгох, хэрэглэгчдэд холбогдох мэдээллийг түргэн шуурхай, энгийн байдлаар хүргэх | Цахим хуудсаар лавлах цэгээр түгээсэн мэдээллийн тоо, Цахим хуудасны хандалтын тоо, Лавлах цэгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоо, хувиар, Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | Гаалийн цахим үйлчилгээний систем *https://gaali.mn/* : 2023 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 281 аж ахуй нэгж, иргэн "Барааны экспорт, импортын статистикийн мэдээлэл"-ийг авсан хандалт хийсэн.<br>Гаалийн цахим үйлчилгээний систем *https://gaali.mn/*: 2023 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 3768 аж ахуй нэгж, иргэн | 1.Гаалийн болон бусад хууль тогтоомжийн мэдээллийг тухай бүр түгээсэн байна.<br>2.Гадаад худалдааны статистик мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч /хандалт/, цахим лавлагаа авсан хэрэглэгчийн тоо өмнөх оны мөн үеэс 5 хувиар өссөн байна.<br>3.Хэрэглэгчдийн мэдээлэл авах хүсэлтийг цахимаар авдаг, | Нэг. Гаалийн тухай хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг хангасан ААН-д түр агуулах ажиллуулах зөвшөөрлийн хүсэлтээ тусгай зөвшөөрлийн цахим систем license.mn-ээр гаалийн байгууллагад илгээж, хянуулж, шийдвэрлүүлэх боломж нээлттэй байдаг. Тусгай зөвшөөрлийн цахим систем license.mn-ээр 2024.01.01-ний өдрөөс 2024.06.25-ны өдрийн байдлаар түр агуулах ажиллуулах зөвшөөрлийн хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байхгүй, 1 аж ахуйн нэгжээс ирүүлсэн түр агуулахын зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтийг хянаж байна.<br>Хоёр. АНУ-ын ЭСЯ-тай хамтран ажиллаж, Монгол Улсын гаалийн байгууллага болон Оюуны өмчийн газрын албан хаагч нарыг чадавхижуулах "Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт" сэдэвт сургалтыг 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, ГЕГ болон харьяа 9 газрын 30 албан хаагч нарыг оролцуулсан. Тус сургалтад АНУ-ын Нью Йорк мужийн Зүүн дүүргийн шүүхийн | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | "Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа" авсан. | хүргүүлдэг болсон байна. | шүүгч Пэгги Куо, Патент, барааны тэмдгийн газрын Олон улсын харилцаа, бодлогын албаны Хуулийн хэлтсийн өмгөөлөгч-хуульч Марк Абумери, Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны дэргэдэх Олон улсын Компьютер хаак, Оюуны өмчийн газрын тусгай төлөөлөгч Томас Софиа, Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны Гуанжоу дэх Бүсийн дэд атташе Адам Жефферсон, Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны Бээжин дэх Бүсийн дэд атташе Стивин Тимминс нар цахим орчин дахь эрхийн зөрчил, хуурамч барааг онилох, хуурамч барааг таних, хуурамч эмийн хил дамнасан худалдааг илрүүлж, таслан зогсоосон тодорхой тохиолдолд үндэслэн танилцуулга хийсэн. Дээрх сургалтын материалуудад үндэслэн сургалтад оролцогч нараар дамжуулан өөрсдийн ажиллаж байгаа газар, хороодын бусад албан хаагч нартаа мэдээлэл түгээх арга хэмжээг зохион байгуулсан.<br>Оюуны өмчийн хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг гаалийн газар, хороодын дарга нарт тухай бүр хүргүүлж ажилласан. Тайлант хугацаанд Баянгол мед ХХК-ийн хүсэлтийн дагуу LPG барааны тэмдгийг гаалийн бүртгэлд бүртгүүлж хамгаалуулах тухай хүсэлтийг хүлээн авч хянан, гаалийн бүртгэлд авсан.<br>ГЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн газарт гаалийн үйлчилгээний цахим систем gaali.mn системийн үйлчилгээ цэсний Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн байгууллагад бүртгүүлэх хүсэлт гаргах, баталгаажуулах хэсгийг хэрэглээнд нэвтрүүлж, CAIS системд холбох холболт хийх тухай дотоод зурвасыг хүргүүлэн хамтран ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | 1.7.Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -2019 оны Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна. Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг 2023 онд хийсэн.<br>-2019 онд хийгдсэн Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах судалгааны дүнтэй 2023 онд хийсэн судалгааг харьцуулж байна. | -Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааг хийж, дуусгасан байна. | Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн нэгжээс "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системд оролцогч 19 байгууллагын 40 албан хаагчийг оролцуулсан уулзалтыг 2024.03.21-ний өдөр зохион байгуулагдсан. АХБ-тай хамтран "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн цахим нэг цонх хариуцсан гадаад зөвлөхөөс:<br>-Training on single windows data harmonization,<br>-Training on single window business process reengineering сургалтуудыг 2024.03.21, 22-ны өдрүүдэд ГЕГ-т зохион байгуулж, ГЕГ-ын бүтцийн нэгжийн 18 албан хаагчийг оролцуулсан.<br>Мөн "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагаа 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан 2024.03.25-ны өдөр зохион байгуулагдсан. Тус хуралдаанаар ажлын хэсгийн гишүүд дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:<br>-Ажлын 7 хоногт багтаан гүйцэтгэгчээс шинэчилж ирүүлсэн даалгаврыг Н.Энхцацрал хариуцан ажлын хэсгийн гишүүдэд тараах, улмаар ажлын хэсгийн гишүүд ажлын 5 хоногт багтаан танилцаж, саналаа ирүүлэх;<br>-Ажлын даалгавартай танилцаж ирүүлсэн гишүүдийн саналыг нэгтгэж, эцэслэсний дараа, дараагийн хурлыг зохион байгуулж, ажлын даалгаврыг батлах;<br>-Сонгон шалгаруулалтыг 2024 оны 05 дугаар сард багтаан зарлах;<br>-PMO-ийг мэргэжлийн зөвлөх, инженерүүдийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулах талаар санал хураах, 100 хувийн саналаар дэмжсэн;<br>-PMO нь ГЕГ-ын байранд байрлаж, ажиллах бөгөөд ГЕГ-аас ажиллах нөхцөлөөр хангах; | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -PMO-ийн гишүүдийг сонгон шалгаруулах ажлын даалгаврыг “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-өөс боловсруулж, яаралтай ирүүлнэ.<br>“Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийг хэрэгжүүлэгч байгууллага өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ажлын төлөвлөгөөнд тусгасан хугацааг шинэчилж, үйл ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна. Тус ажлын хэсгийн гишүүд 2024.06.20-ны өдөр хуралдаж, ажлын хэсгийн гишүүн бүрээр ажлын даалгаврыг баталгаажуулж, саналыг нэгтгэсэн. | | |
| 8 | 2.2.Дэлхийн худалдааны байгууллагын “Гаалийн үнэлгээний хэлэлцээр” болон гаалийн үнэлгээтэй холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.ГЕГ-ын даргын 2012 оны А/30 дугаар тушаалаар батлагдсан “Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох заавар”-ын төслийг боловсруулсан боловч бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэн хийдэг болсонтой холбоотойгоор төслийг шинэчлэх шаардлага гарсан.<br>2.Харьяа гаалийн 18 газар, хороодын бичиг баримтын бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэн хийдэг болсон. | 1.Эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах, гаалийн үнийн хяналтын тогтолцоонд шинэ хандлага төлөвшүүлсэн байна.<br>2.“Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна. | 1. Швейцар Улсын Женев хотноо зохион байгуулагдсан Дэлхийн худалдааны байгууллагын Гаалийн үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарын газраас 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 24-ний өдрийн хооронд зохион байгуулсан “ДХБ-т Гаалийн үнэлгээний асуудлаар мэдэгдэл хүргүүлэх нь” сургалтад БАҮХ-ийн ГУАБ оролцсон. Мөн Дэлхийн худалдааны байгууллагын Гаалийн үнэлгээний хорооны хуралдаанд 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр оролцож, уг хурлаар ДХБ-ын гишүүн орнуудаас 28 гишүүн орны гаалийн үнэлгээний асуудлаарх мэдэгдлийг үүний дотор Монгол Улсын хууль тогтоомж нь ДХБ-ын Гаалийн үнэлгээний хэлэлцээрт нийцэж байгаа эсэх асуудлыг ДХБ-аас хянасан тухай мэдээллийг авч хэлэлцсэн. Гаалийн үнэлгээний Хорооны хуралдаанаас гаалийн үнэлгээтэй холбоотой асуудлуудыг зохицуулж буй Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль зэрэг үндэсний хууль тогтоомж нь ДХБ-ын Гаалийн үнэлгээний хэлэлцээрт нийцэж байгаа тухай Монгол Улсын мэдэгдлийг хүлээн авсан.<br>ДХБ-ын гишүүн орнууд Гаалийн үнэлгээний хэлэлцээрийн 22 дугаар зүйлд заасны дагуу гаалийн үнэлгээний асуудлаарх хууль | 2024.01.01 - 2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоомжоо мэдэгдэхээс гадна тус хууль тогтоомжийн нийцлийг 15 асуулт бүхий "Шалгах хуудас"-аар гаргаж, ДХБ-д мэдэгдэх үүрэг хүлээдэг. Иймд МУ-ын "Гаалийн хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт" Мэдэгдэл 1, "Нягтлах хуудас" Мэдэгдэл 2-ийг англи хэл дээр бэлтгэж, ДХБ болон ГХЯ-нд 2024.06.20-ны өдрийн 01-1/2533 албан тоотоор ГХЯ-нд хүргүүлсэн. Олон улсын гэрээ хэлэлцээрт үндэсний хууль тогоомж нь нийцсэн байх нь ДХБ-ын худалдааны олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, МУ-аас бусад улс оронтой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах, Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, гаалийн үнэ, үнэлгээтэй холбоотой гарч байгаа маргаантай болон бусад асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.<br>2. Гадаад худалдааг хөнгөвчлөх, бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулж байгаа цаг хугацааг багасгах, хүний оролцоог багасгаснаар хязгаарлагдмал боловсон хүчийг зөв хувиарлах, авлигаас ангид байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор гаалийн үнийг автоматжуулах ажлыг хийх шаардлага гарсан. Иймд холбогдох судалгаа, дүн шинжилгээг хийж, эрсдэл тооцон үзэхэд дээр экспортын биржээр арилжаалагдаж байгаа эрдэс баялагын бүтээгдэхүүн болон Япон улсаас импортолж байгаа дуудлага худалдааны бичигтэй суудлын автомашины гаалийн үнэлгээг автоматжуулах боломжтой байна. Иймд програмыг хийх, холбогдох эрх зүйн актад оруулах нэмэлт хийх төсөл боловсруулах ажлыг ГЕГ-ын БАУХ, БЦТ, МТГ-ууд хамтран эхлүүлэн, програмын туршилтыг хийж, холбогдох журамд орох нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах ажлыг хийж эхэлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3. 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт импортын барааны бичлэгийн 74.46%-ийг, экспортын барааны бичлэгийн 78.4%-ийг хэлцлийн үнийн аргаар үнэлсэн байна.<br>Гаалийн үнийн нэгдмэл байдлыг хангах, гаалийн үнийн хяналтыг сайжруулах зорилгоор дараах ажлыг хийсэн. Үүнд:<br>- Үнийн мэдээллийн санг 54,553 барааны үнийн мэдээллээр баяжуулан гаалийн үнийн хяналтын зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр хэлцлийн бус аргаар гаалийн үнийг тодорхойлсон нийт бичлэгийн 38%-ийг “Үнийн мэдээллийн сан”-гийн “Баталгаажсан үнийн мэдээлэл”-тэй харьцуулан гаалийн үнийг тодорхойлсон бөгөөд нэмж ногдуулсан татварын зөрүү 47.5 тэрбум төгрөг байна.<br>- БНСУ, АНУ, БНХАУ-аас импортолж байгаа суудлын болон ачааны машин, чирэгч, чиргүүлийн үнийн судалгааг шинэчлэн хийж, мөн ОХУ-аас импортолж байгаа вагоны үнийн судалгааг шинээр хийн, CAIS-ийн үнийн судалгааний хавтсанд байршуулан гаалийн үнийн хяналтын зорилгоор ашигласан. Дээрх үнийн судалгаануудын үнээр нийт 5516 барааны гаалийн үнийг тодорхойлсон бөгөөд нэмж төлүүлсэн татварын зөрүү 14.5 тэрбум төгрөг төгрөг байна.<br>- Хилийн үнийн судалгааг тухайн гаалийн газраас хийж ирүүлснийг БАҮХ-ээс хянаж баталгаажуулдаг байсан бол ГГХ, БЦТ болон ГЕГ-ын уялдаа холбоог сайжруулах, барааг таних, нөхцөл байдалтай танилцах, туршлага судлах зорилгоор ГЕГ-ын даргын тушаалаар БАҮХ, Бүрдүүлэлтийн цахим төв, МҮХАҮТ, ЗҮГГ-ын бүрэлдэхүүнтэйгээр үнийн судалгааг анх удаа хамтран хийж, баталгаажуулан гаалийн үнийн хяналтын зорилгоор ашиглах арга хэмжээг авсан. Хил орчмын үнийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | судалгааны үнээр нийт 110,035 барааны гаалийн үнийг тодорхойлсон бөгөөд нэмж төлүүлсэн татварын зөрүү 21.8 тэрбум төгрөг байна.<br>4. БНХАУ-ын төмрийн үнийн мэдээллийг цахимаар шалгах нээлттэй биржийн цахим хуудас/ www.lgmi.com/-т хандах 1 жилийн албан ёсны эрхийг авсан. Тус сайтад хандсанаар өдөр тутмын төмрийн үнийн мэдээллийг хархаас гадна, 1 жилийн үнийн мэдээллийн түүх, тээврийн зардлын мэдээллийг ГЕГ-ын БАҮХ болон БЦТ гаалийн үнийн хяналтын зорилгоор ашиглах боломж бүрдсэн.<br>5. Импортын барааны гаалийн үнэ, үнэлгээтэй холбоотой ААН, иргэдээс ирүүлсэн анхан шатны шийдвэрийг давж заалдсан 57 гомдлыг судлан, 55 гомдлын хариуг албан бичгээр, 1 албан бичгийг утсаар, 1 гомдлын хариуг ДХШАБГ-т дотоод зурвасаар, хүргүүлж хугацаанд нь шийдвэрлэн ажилласан бөгөөд нэмж төлүүлсэн татварын зөрүү 1,8 тэрбум төгрөг байна. Гомдол, маргааны шийдвэрийг тухай бүр CAIS-ийн гаалийн үнэлгээний шийдвэрийн санд бүртгэсэн бөгөөд 309 анхан шатны болон ГЕГ-ын шийдвэр бүртгэгдсэн байна. Мөн экспортын барааны гаалийн үнэлгээний асуудлаар 2 гомдол, хүсэлтийг судлан хариуг хүргүүлэн шийдвэрлэсэн. | | |
| Зорилт 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх | | | | | | | |
| 9 | 3.1.Улсын төсвийн гаалийн орлогыг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй бүрдүүлэх | Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт төгрөгөөр, хувиар | 2023.01.01-06.25-ны өдрийн байдлаар татварын орлогоор 2240.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2179.9 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлж | Төсвийн тухай хуульд заасан гаалийн байгууллагын улсын төсөвт оруулах орлогын төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Улсын төсвийн нийт орлогын төлөвлөгөө эхний хагас жилийн байдлаар өссөн дүнгээр 3297.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс тайлант хугацаа буюу 2024.06.25-ны байдлаар 2988.9 тэрбум төгрөг төвлөрүүлж 90.6 хувийн биелэлттэй байна.<br>Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Үүнээс: Татварын орлогоор 3226.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2024.06.25-ны өдрийн | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 97.3 хувийн биелэлттэй байна. хураамжийн орлогоор 63,7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 70,3 тэрбум төвлөрүүлж төлөвлөгөөний гүйцэтгэл 110,3 хувийн биелэлттэй, Өөрийн орлогоор 7,3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5,6 тэрбум төгрөг төвлөрч биелэлт 77,3 хувьтай байна. | | байдлаар 2912.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 90.3 хувийн биелэлттэй байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 732.7 тэрбум төгрөгөөр илүү буюу 34 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Хураамжийн орлогоор 2024 онд 130.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс эхний хагас жилд 63.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 70.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 110.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 18,6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.<br>-Өөрийн орлого 2024 онд 15.0 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэй, эхний хагас жилд 7.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 5.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 77.3 хувийн биелэлтэй байна. Өөрийн орлогын биелэлтэд БДШГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, тавигдсан төлбөрийн дүн төлөгдөхгүй шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд удаж байгаатай холбоотой байна.<br>6 дугаар сарын өдрийн дундаж орлого 27.6 тэрбум төгрөг байхаар тооцоход, хүлээгдэж буй гүйцэтгэл 3059.1 тэрбум буюу 93.0 хувийн биелэлттэй гарна.<br>Гаалийн байгууллагын төсвийн орлого 93.0 хувийн биелэлттэй буюу 238.2 тэрбум төгрөгөөр тасалдаж байна.<br>Гэвч улсын төсвийн гаалийн орлогыг төвлөрүүлэхэд УИХ, ЗГ-ын гаргасан шийдвэрүүд, ханшийн бууралт, тээвэр ложистикийн нөхцөл байдал зэргээс гаалийн болон онцгой албан татварын тариф тэглэлт 4.1, татварын чөлөөлөлт 1.0, валютын ханшийн бууралтаас 129.25, татварын хойшлуулалт 30.0, тээвэр, ложистик хүндрэлээс 60.0, нийт 224.35 тэрбум | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгийн татварыг төвлөрүүлэх боломж алдагдсан байна.<br>Мөн импортын бараа эргэлтийн урсгалд Монгол Улс руу чиглэсэн чингэлэгийн тоог 40 орчим хувь болгож бууруулсан, Тяньжин боомтод чингэлэг бөөгнөрсөн улмаас 2024 оны эхний 4, 5, 6 дугаар сарын гаалийн орлого 60.0 тэрбум төгрөгөөр тасрахад нөлөөлөл үзүүлсэн байна. | | |
| 10 | 3.3."Чөлөөт худалдааны хэлэлцээр" байгуулах талаар судалгаанд оролцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах ажлын хэсэг болон 14 дэд бүлэгт гаалийн байгууллагын төлөөлөгчид оролцсон. | Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах дараагийн хэлэлцээрт оролцох бэлтгэл ажлыг хангаж, оролцсон байна. | Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээрийн хоёр дахь шатны хэлэлцээ 2024 оны 5 дугаар сарын 21, 22-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан.<br>Хэлэлцээг Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны Чөлөөт худалдааны хэлэлцээрийн бодлогын асуудал хариуцсан дарга Рю Поб Мин нар нээж, хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, стратегийн түвшний түншлэлийн харилцааг хөгжүүлэхэд энэхүү хэлэлцээр нь чухал ач холбогдолтойг онцолсон.<br>Хэлэлцээрийн зорилго нь худалдааны урсгалыг жигд, үр ашигтай явуулахын тулд тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг бууруулах, худалдааг хөнгөвчлөх, эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх хоёр талын хөрөнгө оруулалтыг дэмжих, харилцан ашигтай эдийн засгийн түншлэлээ өргөжүүлэн хөгжүүлэх, хоёр орны бизнес эрхлэгчид, иргэдэд шинэ боломжуудыг бий болгоход чиглэсэн юм.<br>Энэ удаагийн хэлэлцээнд Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хөрөнгө оруулалт, | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | худалдааны газар, Гаалийн ерөнхий газар, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон бусад холбогдох байгууллагуудын нийт 100 гаруй төлөөлөгчид оролцсон. | | |
| Зорилт 4: "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" | | | | | | | |
| 11 | 4.1.Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр, Монгол Улсын Япон Улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, 2017 онд шинэчлэн батлагдсан Төрийн албан тухай хууль, 2019 онд батлагдсан Татварын ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн "Гаалийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар батлуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар батлуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн. | 1.Гаалийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиудыг батлуулах арга хэмжээг авсан байна.<br>2.Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн төсөлд нийцүүлэн журам, зааврыг боловсруулсан байна. | Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны А/03 тушаалаар батлагдсан Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг Зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудад орсон өөрчлөлтүүдийг судалж, хуулийн төслийг нийцүүлсэн. Хуулийн төслүүд, үзэл баримтлалыг "Санал шийдвэрлүүлэх тухай" Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/2842 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн.<br>Ажлын хэсэг Гаалийн тухай хуулийн төслийг 6 бүлэг 395 зүйлтэйгээр боловсруулсан бөгөөд хуулийн төслийн тандан судалгаа, зардлын тооцоо, үзэл баримтлалын төсөл, дагаж батлагдах хуулийн төслүүд зэрэг холбогдох бусад баримт бичгүүдийг боловсруулсан.<br>Хуулийн төсөлд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийг нэгтгэсэн.<br>Хуулийн төсөл, холбогдох бусад материалын хамт Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд тус яамнаас 2024 онд Улсын Их Хурлын сонгуулийн жил бодлогын шинжтэй хуулийн төсөл хэлэлцэхгүй гэсэн чиглэл өгсөн ба | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | одоогийн байдлаар тус яаманд хуулийн төслийг хэлэлцэж эхлээгүй байна.<br>Улсын Их Хурлын сонгуулийн дараа Сангийн яаманд дахин хандаж чиглэл авахаар төлөвлөж байна. | | |
| 12 | 4.3.Гаалийн төв болон салбар лабораторийг олон улсын жишигт нийцүүлэх | Хэрэгжилт, хувиар | 1.Гаалийн төв лабораторийг эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр Олон улсын итгэмжлэлд хамруулах ажлын хүрээнд БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгууллага/CNAS/-ын цахим үнэлгээнд амжилттай хамрагдаж, эрдсийн бүтээгдэхүүнд 14 үзүүлэлтээр, нүүрсэн бүтээгдэхүүнд 8 үзүүлэлтээр, газрын тосны бүтээгдэхүүнд 19 үзүүлэлтээр итгэмжлэхээр шийдвэрлэсэн.<br>2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим | 1.Замын-Үүд дэх гаалийн газрын салбар лабораторийг нефтийн бүтээгдэхүүн, ноос ноолуурын шинжилгээний чиглэлээр, Дорнод аймаг дахь гаалийн газрын салбар лабораторийг химі, нефтийн шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн хүрээг өргөтгөж, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын Гаалийн салбар лабораторийг согтууруулах ундаа, хими, нефтийн бүтээгдэхүүний шинжилгээний чиглэлээр, Гашуунсухайт, Шивээхүрэн, боомтуудын салбар лабораториудыг нүүрсний | 1) ГТЛ нь БНХАУ-ын итгэмжлэлийн үнэлгээний байгуулга CNAS-ийн хяналтын шатны үнэлгээнд амжилттай хамрагдаж, уул уурхайн эрдэс түүхий эд, нүүрс, газрын тосны бүтээгдэхүүний магадлан шинжилгээний чиглэлээр итгэмжлэлийн эрхээ сунгав.<br>2) Гаалийн салбар лабораториудыг MNS ISO/IEC 17025:2018 "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага" стандартын дагуу үндэсний итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажлыг шалгах хүрээнд дотоод аудит явуулах төлөвлөгөөг боловсруулж, батлан, мөрдөж ажиллав.<br>3) СЭГГ-ын салбар лабораторид 2024.05.02-08 хооронд, ЗҮГГ-ын салбар лабораторид 2024.06.03-10 хооронд дотоод аудит хийж, илэрсэн үл тохиролыг залруулан ажиллах хугацаатай үүрэг даалгавар өгч, ирүүлсэн тайланг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Мөн үндэсний итгэмжлэлд хамруулах бэлтгэл ажлыг хангуулах хүрээнд тус салбар лабораториудын чанарын тогтолцооны бичиг баримт болох чанарын гарын авлага, дагалдах журмуудыг хянаж, засварлан, тухайн гаалийн газрын даргаар батлуулав.<br>4) Гаалийн лабораториудын магадлан шинжилгээний үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх буюу шинжилгээний тоног төхөөрөмжийн үр дүнг лабораторийн мэдээллийн менежментийн систем (LIMS)-д нэвтрүүлэн ажиллав. Үүнд: | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэлбэрт шилжүүлэх “Лабораторийн мэдээллийн менежментийн систем” /LIMS/-ийг гаалийн төв лабораторийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. | чиглэлээр, Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын салбар лабораторийг нефтийн чиглэлээр дотоодын итгэмжлэлд хамруулсан байна.<br>2.Гаалийн лабораторийн тоног төхөөрөмжийн шинжилгээний үр дүнг цахим хэлбэрт шилжүүлэх | - ГТЛ, ДОГГ аймгийн төв болон Баянхошуу боомтын, БӨГГ, СШГГ, ОРГГ-ын салбар лабораториудад LIMS-ийг бүрэн нэвтрүүлсэн.<br>- ЗҮГГ, СЭГГ-ын салбар лабораториудад барилгын ажлын үйл явцаас хамаарч энэ онд багтаан нэврүүлэхээр сорилтын дүнгийн мэдээлэл, стандарт арга аргачлалын жагсаалт гаргах зэргээр бэлтгэл ажлын ханган ажиллаж байна. | | |
| 13 | 4.7.Эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, албаны эрэлч нохойн ашиглалтыг нэмэгдүүлэх | Эрэлч нохойн тоо, Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоо, Илрүүлсэн зөрчлийн тоо, хувиар | 1. Эрэлч нохойн тоог 5-аар нэмэгдүүлж, нийт 48 эрэлч нохойтой<br>2. Гаалийн ерөнхий газрын харьяа 11 газар хороодод 28 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч эрэлч нохойн хамтаар ажиллаж байна.<br>3. Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч нарын тоог 5 хувиар нэмэгдүүлж ажилласны үр дүнд албаны | 1.Эрэлч нохойн тоог 5-аар нэмэгдүүлж, нийт 49 эрэлч нохойтой болно.<br>2. Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийн тоог 5-аар нэмэгдүүлж, сургана.<br>3. Эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж, зөрчил илрүүлэлтийг өмнөх оны мөн үеэс 5 хувиар нэмэгдүүлнэ. | 1. Эрэлч нохойн тоог нэмэгдүүлж ажлын хүрээнд 2024 оны үржлийн хөтөлбөрт хамрагдах нохойг сонгосон. ГЕГ-ын нийт данс бүртгэлд буй 48 нохойноос судалгаа авч үржилд орох боломжтой 2-4 насны 19 ширхэг нохой байснаас 15 нохой нь эр хүйстэй, 4 нохой нь эм хүйстэй байсан. Үүнээс ЭНСТ дээр 2-4 насны 1 ширхэг эм нохой 4 ширхэг эр нохой байсан ч үүлдрийн хувьд таарахгүй болсон тул УХШИГГ-ын **Лоло** дуудлагатай эм нохойг ЭНСТ-ийн **Коко** дуудлагатай эр нохойн хамт сонгон нийллэгт орулах ажил хийгдэж байна.<br>2. ГЕГ-ын харьяа 7 газар хороодын 13 эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчийг эрэлч нохойн хамт 4 удаагийн сургалтад хамруулсан.<br>Сургалтад хамрагдсан эрэлч нохдын зорилтод үнэрүүдийг таньж, эрж олох чадвартайг болсоныг сургалтын зааланд | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрэлч нохойг ашиглан 20 зөрчил илрүүлэн ажилласан. | | тусгайлан зассан хэсэгт шалгаж тодорхойлсон.<br>ЭНСТ-ийн анхан болон давтан сургалтуудад хамрагдаж бэлтгэгдсэн 11 нохойгоор нэмэгдүүлсэнээр 33 эрэлч нохойтой болсон. Үүнд: ЧХОУНБГГ-т 3 нохой, ДоГГ-т 1 нохой, СшГГ-т 1 нохой, ЗүГГ-т 1 нохой, УБГГ-т 2 ЭНСТ- 3 нохойгоор тус тус нөхөн хангалт хийсэн. Мөн албаны нохойн ажлын бүтээмжид шууд нөлөөлөх эрэлч нохдод шаардлагатай амин дэм эрдэс витаминаар баялаг зориулалтын үйлдвэрийн хоол, эрүүл мэндэд шаардлагатай эм тариа зэргийг газар хороодод тараасан.<br>3. 2024 оны эхний хагас жилийн байдлаар 13 газар хороодод 33 эрэлч нохой ажиллаж 12 зөрчил илрүүлсэн. Үүнд:<br>1-р сард БӨГГ 1 зөрчил,<br>3-р сард ЧХОУНБГГ-1 зөрчил, СэГГ 1 зөрчил,<br>4-р сард ЗүГГ-2 зөрчил, СэГГ 1 зөрчил, ДоГГ-2 зөрчил<br>5-р сард ЗүГГ 1 зөрчил, СэГГ 3 зөрчил тус тус илрүүлсэн. Зөрчил илрүүлэлтийн байдлыг 2023 оны эхний хагас жилтэй харьцуулахад 55.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. | | |
| 14 | 4.15.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх | Хэрэгжилт, хувиар | 1.Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилга байгууламж, автозам зогсоолын барилгын ажлын нийт гүйцэтгэл 92%-тай. Улсын комисс 2023 оны 09 дүгээр сарын | 1.Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын | Гаалийн хяналтын бүсэд оруулж, гаргаж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэх ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг суурилуулж, бодит цагийн горимд ГТСМТТ УҮГ-ын smartgate.ecustoms.mn системд холбуулах даалгаврыг 2024.02.28-ны өдрийн 02-1/762 дугаартай албан бичгээр гаалийн хяналтын бүс эзэмшигч нарт хүргүүлсэн. Дээрх ажилтай холбогдуулан ухаалаг гарцын тоног төхөөрөмж болон системд тавигдах шаардлагыг gaali.mn -ын “Гарын авлага, заавар” хэсэгт байршуулж, мэдээлэл өгсөн. | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 28-ны өдөр, 1-р ээлжийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>2.Бичигт боомтын авто замын барилгын ажлын гүйцэтгэл 25%, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 5%.<br>3.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 64.8%- ийн гүйцэтгэлтэй.<br>4. Шивээхүрэн, боомтын ТЭЗҮ, БОТБҮ, нарийвчилсан зураг төслийн ажил 100%-д хүрсэн.<br>5.ЭЗХЯ-ны захиалгаар ТХААГ-аас Эрээнцав, Арцсуурь боомтын ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын тендер зарлагдаж гүйцэтгэгчийг сонгон | зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.<br>2.Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 50%-д хүрсэн байна.<br>3.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна.<br>4.Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br>5.Даян, Байтаг, Тэс, Арцсуурь, Эрээнцав, Бага- | Дээрх албан даалгаврын хүрээнд УБГГ-ын хяналтад үйл ажиллагаа явуулж байгаа гаалийн хяналтын бүсийн эрхлэгч нартай 3 удаа уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтуудаар гаалийн хяналтын бүсийн эрхлэгч нараас:<br>-“Алсын хараа 2050” бодлогын бичиг баримттай холбоотойгоор “Улаанбаатар хотын ачаа тээврийн нэгдсэн ложистикийн төв”-ийг УБ хотоос зүүн урагш 34 км-ийн зайд байгуулж, 2024 оны сүүлч, 2025 оны онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.<br>-гаалийн хяналтын бүсүүдэд ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулахад 55-70 орчим сая төгрөгийн зардал гарахаар тооцоолол гарсан.<br>Ийм учраас ложистикийн төвүүдийг шилжүүлэх дээрх төлөвлөлттэй холбоотой шийдвэрийг хүлээх шаардлагатай байна гэсэн байр суурь илэрхийлсэн.<br>Харин Өмнөговь аймгийн Цагаанхад суурьшлын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа:<br>-24 гаалийн хяналтын бүсэд суурилуулсан;<br>-7 гаалийн хяналтын бүсэд суурилуулах ажил хийгдэж байгаа;<br>-14 үйл ажиллагаагаа түр зогсоосон гаалийн хяналтын бүс эзэмшигч нар суурилуулах гэрээ байгуулсэн.<br>Шивээхүрэн боомтоор нүүрс экспортлогч 6 компани уурхай дахь талбайд ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулсан. ГТСМТТ УҮГ-тай холбогдон програмын хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байна.<br>Алтанбулаг боомт:<br>Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл RIBS -ээс Алтанбулаг боомтод суурилуулах ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн тендерийн сонгон шалгаруулалт зохион байгуулахаар ажиллаж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгаруулсан. Зураг төслийн ажлын явц Эрээнцав боомт 30%, Арцсуурь боомт 45%-ын гүйцэтгэлтэй.<br>6.Гашуунсухайт боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулах ажлыг бүтээн байгуулалттай уялдуулан гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 35% байна. Боршоо, Алтанбулаг боомтод суурилуулах ухаалаг гарцын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлагдсан ба эцэслэгдээгүй байна. Ханги боомтод ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулахаар байршлыг тодорхойлохоор ажлыг хэсэг газар дээр нь ажиллаж санал боловсруулсан. | Илэнх, Зэлтэр боомтуудыг хөгжүүлэх, дэд бүтцийг өргөтгөж шинэчлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний нарийвчилсан зураг төслийн ажлын даалгаварт тусгах саналыг боловсруулан гүйцэтгэгч байгууллагад өгч хамтран ажилласан байна. Зураг төсөл Барилгын хөгжлийн төвөөр баталгаажсан байна.<br>6.Алтанбулаг, Баянхошуу, Гашуунсухайт боомтуудад ухаалаг гарцын системийг нэвтрүүлсэн байна.<br>7.Цагаандэл уул боомтын БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгийн буцалтгүй тусламжаар бүтээн байгуулах төсөл хэрэгжүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан | байна. Тус төслийн нэгжид Алтанбулаг боомтод суурилуулах 16 нэр төрлийн нийт 376 ш тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн шаардлагыг хүргүүлэх санал өгсөн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 7.Цагаандэл уул боомтын зураг төслийн ажлын гүйцэтгэл 85%-тай. Боомтын түр гарц нээж гадна хашаа барих ажлын явц 90%-ийн гүйцэтгэлтэй. | тохиолдолд түр гарц нээх, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна. | | | |
| 15 | 4.16.Гаалийн төв болон салбар лабораторийн чадавхыг бэхжүүлэх | Дээжийн тоо, хувиар, Магадлан шинжилгээнд зарцуулах хугацаа, хоногоор | ."Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын салбар лаборатори болон Увс аймгийн Боршоо дахь гаалийн салбар лабораториудыг хэвийн үйл ажиллагаанд оруулж эхлүүлж ажилласан.<br>3.Гаалийн төв лаборатори болон Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын Цагаан нуур дахь салбар лабораторид хорио цээрийн шинжилгээг нэвтрүүлсэн. | 1.Булган, Цагаандэл-Уул, Бургастай боомтод шинээр салбар лабораторийг байгуулан нүүрс, эрдэс түүхий эдийн шинжилгээний тоног төхөөрөмжийг суурилуулж, үйл ажиллагаанд оруулснаар магадлан шинжилгээнд хамрагдах нийт дээжийн тоог 5-10 хувиар нэмэгдүүлнэ.<br>2.Булган, Цагаандэл-Уул, Бургастай боомтод шинээр салбар лабораторийг байгуулснаар тус гаалийн газрын хяналтад байгаа барааны магадлан | **Гаалийн төв лаборатори:** Тус лабораторид хүсний хорио цээрийн шинжилгээ хийх шинжээчид томилогдсон бөгөөд хорио цээрийн шинжилгээний тоног төхөөрөмжүүдийн тохиргоо хийж, сургалтыг зохион байгуулж, шинжилгээний өрөөнүүдийг стандартын дагуу өөрчлөн,шаардлагатай санхүүжилтийг тухай бүр ГЕГ-ын СХОГ тавьж шийдвэрлүүлснээр хорио цээрийн туршилтын шинжилгээг эхлүүлсэн.<br>**ЧХОУНБГГ-ын ГСЛ:** Тус СЛ-д 5 Шинжээч-ГУБ-г ГТЛ дээр дадлагажуулсан. Хими, хорио цээрийн шинжилгээний нийт 30 тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэгч компаниуд суурилуулан, тохиргоо хийж, сургалт явагдаж, хэвийн үйл ажиллагааг хангасан. Турштлтын шинжилгээг эхлүүлсэн. 1 төхөөрөмж цахилгаанаас түр хүлээгдэж байна.<br>**УвГГ-ын ГСЛ:** Тус СЛ-д томилогдсон 1 ГУБ- шинжээчийг ГТЛ-д нефть, хорио цээрийн шинжилгээний чиглэлээр 14 хоног сургалтад хамруулснаар хэвийн үйл ажиллагаанд оруулж, шинжилгээг эхлүүлсэн. 36 дээжинд магадлан шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. Нефтийн шинжилгээний 10 төхөөрөмжүүдийг суурилуулж байна. Боловсон хүчин дутагдалтай хэвээр байна.<br>**Булган боомтын ГСЛ:** Тус СЛ-д хүнсний хорио цээр, эрүүл ахуйн анхан шатны шинжилгээний 22 багажийг нийлүүлсэн, холбогдох туршилтын шинжилгээ хийгдэж | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээнд хамрагдах хугацааг 3-4 хоногоор бууруулна.<br>3.Гаалийн төв лабораторид импортын зарим хүнсний бүтээгдэхүүнд нян судлал, хор судлал, ургамлын хорио цээрийн шинжилгээ хийж эхэлнэ. | байна. Одоо байгаа ГСЛ-ын зургийн өөрчлөлтийг гаргаж, шинжилгээний өрөөнүүдийн зохион байгуулалт, багажийн мэдээллийг дэлгэрэнгүй гаргаж, зургийн компани болон БХХ-т хүргүүлсэн.<br>Цагаандэл-Уул, Бургастай боомтын бүтээн байгуулалттай холбогдуулан шинээр байгуулах салбар лабораторийг түр хойшлуулсан.<br>Боомтын гадаад худалдааны бараа эргэлт, нэвтрүүлэлтийг үндэслэн Цагаан дэлд нүүрсний чиглэлээр, Бургастайд эрдэс бүтээгдэхүүний шинжилгээний төхөөрөмжүүдийн жагсаалт, лабораторийн өрөөний зохион байгуулалтыг гаргаж, БХХ-т хүргүүлсэн.<br>***Салбар лабораториудад хийгдсэн бусад ажил:***<br>- ГСГГ-ын Оюутолгой ГСЛ-ийн барилгын агааржуулалтыг сайжруулах ажлыг “Оюутолгой” ХХК гүйцэтгэхээр шийдвэрлэгдсэн. Одоогоор ГТЛ дээр зэсийн баяжмалаа хийж гүйцэтгэж байна. Нийт 143 дээжинд шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан.<br>- ЗҮГГ-ын ГСЛ-ийн одоогийн барилгыг нүүрсний шинжилгээний чиглэлээр өөрчилж, өрөөнүүдийн зохион байгуулалтыг гаргаж, зургийн компанид БХХ-т хүргүүлсэн. Хорио цээрийн лабораторийг ашиглалтанд оруулсан.<br>- СЭГГ-ын Алтанбулаг боомтод баригдаж буй ГСЛ-ийн барилгын 1, 2-р давхарын өрөөний хана, шалны материал, ус холболт, бусад өөрчлөлтийн талаарх саналыг зургийн компани болон БХХ-т хүргүүлсэн<br>Тайлант хугацаанд хилийн боомтууд дээр ажиллаж байгаа 8 салбар лаборатори 10 шинжилгээний төрлөөр 12161 дээжинд магадлан шинжилгээ хийж, 7444 дүгнэлт гаргаж, 148 зөрчил илрүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГТЛ болон салбар лабораториудад магадлан шинжилгээг хийж гүйцэтгэснээр нийт дээжний тоог 5-10 хувиар нэмэгдүүлж, магадлан шинжилгээнд хамрагдах хугацааг 1-3 хоногоор бууруулсан. | | |
| 16 | 4.17.Гаалийн хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цахимжуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.Алтанбулаг, Замын-Үүд, Боршоо боомтуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангасан.<br>2.ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээтэй боомт байхгүй байна.<br>3.ГЕГ-ын даргын 2023 оны 62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг Экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх | 1.Хилийн Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөгөөр хангагдсан байна.<br>2.ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээ авах бэлтгэл ажлыг Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь гаалийн газар хангасан байна.<br>3.Экспортын гэрчилгээ, дамжуулан өнгөрөх | 1. Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн болон бусад боомтуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг авахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, ариутгалын байгууламж, сэжигтэй зорчигчийг түр тусгаарлах өрөөний судалгааг гаргаж, 5 байгууламж 35 нэрийн 417 ширхэг тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн 12,019,560,411.3 төгрөгийн төсвийг 2025 оны төсвийн тодотголд оруулахаар хүргүүлсэн.<br><br>“Шивээ хүрэн-Сэхэ боомтын төсөл”-ийг хэрэгжүүлэгч “Нарийн сухайтын төмөр зам” ХХК-ийн бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцаж, усан хангамж, бохир усны зайлуулалт, хил, гаалийн ажилчдын ажлын болон ахуйн байр, түр тусгаарлах өрөөний зураг төслийн баримт бичгийг зөвшилцсөн.<br>2025 онд шинээр барьж байгуулах Бичигт хилийн боомтын цогцолборын зураг төсөл болон, холбогдох байгууламжуудын техникийн тодорхойлолтыг боловсруулсан.<br>ГЕГ-ын даргын 2024 оны 130 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хороо батлуулах тухай” ажлын хэсэгт ажиллан, техникийн тодорхойлолт боловсруулан, тендерийг шалгаруулж, 7 Гаалийн газар, хороонд /Бичигт, Шивээхүрэн боомт гэх мэт/ 8 зорчигчийн халуун хэмжих төхөөрөмжийн хангалт хийсэн.<br>"Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааны төсөл /BEST/"-ийн санхүүжилтээр Хавирга, Цагааннуур, Булган боомтуудад “Нэг-Эрүүл мэнд” бодлогын хүрээнд хийгдэх ажлуудын саналыг өгсөн. | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдэгдлийг цахимаар олгох судалгаа хийсэн.<br>4.ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний баг Монгол Улсад 2023 оны 11 дүгээр сарын 17-24 ний өдрүүдэд ажилласантай холбогдуулан 18 гаалийн газар, хороодоос судалгаа авч, 5 боомтод мэргэжлийн байгууллагатай хамтран газар дээр нь үнэлгээг хийж, үнэлгээний нэгдсэн дүнг Шадар сайдын түвшинд танилцуулж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг гаргасан.<br>5.Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй | мэдэгдлийг цахимаар олгох бэлтгэл ажлыг хангаж, нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.<br>4.ДЭМБ-ын Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийг хэрэгжүүлэх үндсэн чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээний багаас Засгийн газарт хүргэгдсэн нэгдсэн зөвлөмжид тусгагдсаны дагуу 19 Газар, хороодын "Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний төлөвлөгөө"-г Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар баталсан журмын үйл явдал бүрээр нарийвчлан боловсруулж, батлуулах<br>5.Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг | Булган боомт шинэчлэлт, төлөвлөлт болон Бичигт-Зүүн хатавч, Сүмбэр-Рашаант боомтод ОУЭМД-д заасан шаардлагыг хангуулах саналыг дэвшүүлсэн.<br>2. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/85 дугаар тушаалаар батлагдсан "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын дагуу Цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх Монгол Улсын чадавхыг "Нэг эрүүл мэнд" зарчимд тулгуурлан бэхжүүлэх төслийн техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллан ДЭМБ-ын ОУЭМД-ийн шаардлага хангасан чадавхын гэрчилгээ авах бэлтгэл ажлыг "Чингис хаан" ОУНБ дахь гаалийн газарт хийх ажлын хүрээнд тус боомтын чадавхийн өнөөгийн үнэлгээний үнэлгээг хийх асуумжийг боловсруулсан.<br>Олон улсын аялал жуулчлал, зорчигчийн нэвтрэх хурд, бүртгэлийн цэгийн тоо нэмэгдүүлэх, үзлэгийн цэгийн талбайг өргөтгөх, зорчигчийн эрүүл мэнд болон гэрийн тэжээвэр амьтны үзлэгийн цэгийг нислэг үйлдвэрлэлтэй уялдуулан өөрчлөх ажлын хүрээнд 2024 оны 3 дугаар сард Чингис хаан ОУНБ-ын олон улсын явах бүртгэл, бизнес лонжийн хэсэгт байрлах 3 ширхэг цацрагийн хяналтын төхөөрөмжийг байрлалыг өөрчлөх 47 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт компанитай хамтран хийж гүйцэтгэсэн байна.<br>3.Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж, 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс экспортын гэрчилгээ, импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох, баталгаажуулах чиг үүрэг ХХААХҮЯ, МЭЕГ-т шилжсэн тул | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байдлыг сайжруулах нь” төслийн хүрээнд ГЕГ-ын даргын 2023 оны А/62 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг гаалийн хорио цээрийн үйл ажиллагааг цахимжуулах 16 модулийг боловсруулж, энэ хүрээнд одоогийн үйл ажиллагааны /AS-IS/ болон ирээдүйн үйл ажиллагааны системийн зорилтот /To-Be/ загварчлалыг бэлэн болгосон. | сайжруулах нь” төслийн хүрээнд “Хилийн хяналт удирдлагын систем”-ийн хөгжүүлэлтийн хүрээнд www.gaali.mn цахим системээр дамжуулан гаалийн харилцаанд оролцогчдын өргөдөл, гомдол мэдээлэл хүлээн авах нэгдсэн сувгийг бий болгох, хорио цээрийн эрсдэл тооцох аргачлалыг програмчлах, гаалийн автоматжуулсан цахим системийн зарим модулийг гар утасны программд шилжүүлэн ашиглах апплейкшныг боловсруулж, нэвтрүүлнэ. | зөвхөн гаалийн газар, хороодоос олгох импортын гэрчилгээ олгох үйл ажиллагааг хялбарчлах, цахимжуулах программын даалгаврыг боловсруулсан. Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагаа, импортын гэрчилгээний олголтын талаар газар, хороодод цахимаар болон албан бичгүүдээр чиглэл өгсөн.<br>Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бараанд импортын мэдэгдэл 82 ш, экспортын гэрчилгээ 1506ш, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд 903 ширхэг экспортын гэрчилгээ, дамжин өнгөрүүлэх мэдэгдэл 79 ширхэг, импортын мэдэгдэл 1175 ширхэгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, 2-4 цагийн хугацаанд шуурхай олгосон<br>БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт мах, махан бүтээгдэхүүний экспортын мэдээг Нэг цонхны үйлчилгээний хүрээнд цахимаар солилцож хамтран ажилласан.<br>4. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/85 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу Цартахлаас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх Монгол Улсын чадавхыг “Нэг эрүүл мэнд” зарчимд тулгуурлан бэхжүүлэх төслийн техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллан, 18 Газар, хороодын “Нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар баталсан журмын үйл явдал бүрээр боловсруулж, эхний төслийг бэлэн болгосон.<br>5. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Шадар сайдын ажлын алба болон Интерактив ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангах арга хэрэгслийг сайжруулах" төслийн хүрээнд гаалийн хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргын А/115 тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн батлуулж, 16 модулийн хүрээнд төлөвлөгөө гарган Хорио цээрийн эрсдлийг, гаалийн эрсдэлийн удирдлагын модультай уялдуулах зорилгоор эрсдэлийн нэгдсэн журамд дурьдсан эрсдэл тооцох өгөгдлүүдийг цахимжуулах, төрийн байгууллагуудтай өгөгдөл солилцох, лабораторийн модулийн шаардлагын тодорхойлолт, гар утасны апплейкшнын загвар, хорио цээрийн модулийн цацраг, шарил, зорчигч, тээвэр, халдваргүйжүүлэлтийн дэд модульд засвар, сайжруулалт, хорио цээрийн хяналтын явцад буцаах мэдэгдлийн модулыг, хяналтын чиглэл бүрийн зааврыг тус тус боловсруулсан. | | |
| 17 | 4.20.IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) –той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | -ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээж мэдээллээ солилцож эхлэхээр тохиролцсон.<br>-Гаалийн автоматжуулсан мэдээллийн CAIS системд TIR-EPD мэдээллийг хүлээн авах, боловсруулах программыг | ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээлгэнэ. | IRU-ийн зөвлөх Вахтанг Зарандиятай 2024.05.22-ны өдөр харилцан санал солилцож, TIR-EPD-ийн туршилт хийсэн 4, яаралтай турших 2, цаашид үргэлжлүүлэн турших 6 элементийг тохиролцсон. МТГ-аас 2024.05.09-ний өдрийн А4-05/04 дугаартай дотоод зурвасаар TIR-EPD-г цахимаар хүлээн авах хөгжүүлэлтийг хийж дуусгасан мэдээллийг хүлээн авсан. Дээрх мэдээллийг үндэслэн хилийн чанадад болон Монгол Улсад бичигдсэн ТИР-ын бодлогын даалгавар боловсруулан 2024.05.29-ний өдрийн 211 дугаартай зурвасаар хүргүүлэн хамтран ажиллаж байна.<br>TIR-EPD-г Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системтэй холбож, 2024 оны 7 дугаар сард Замын-Үүд Эрээн боомтод IRU, Монгол Улсын ГЕГ, БНХАУ-ын ӨМӨЗО- | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжүүлэлтийг хийж, тест хийж ажилласан. | | ны Хөх хотын гаалийн байгууллагууд туршилтыг хамтарч хийхээр ажиллаж байна. Мөн TIR-EPD-Г CAIS системтэй уялдуулж, холбох ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024.06.03-ны өдөр ажиллаж байна. | | |
| 18 | 4.21.Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг CEPS-д нөхөж бичээд, гаалийн байгууллагын CAIS-т илгээж бүртгүүлж байна. | Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг гар утаснаасаа гаалийн байгууллагын CAIS системд илгээх, мобайл аппликейшн шинээр хийлгэх бодлогын даалгавар боловсруулж, Мэдээллийн технологийн төвд хүргүүлнэ. | Автозамын хилийн боомтуудаар нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулах зорилгоор бүртгэлийг ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөр бүртгэх ажлыг боомтын шинэчлэлтэй уялдуулан Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудад үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Иймд боомтын орох, гарах хаалганы эгнээ замууд дээр бүртгэлтэй холбоотой асуудлаар бөөгнөрөл үүсгэхгүйн тулд тээврийн хэрэгслийн жолооч нар гар утаснаасаа бүртгүүлэх хүсэлтээ илгээх боломжийг бүрдүүлэхээр гар утасны апп шинээр хийлгэхээр судалгаа хийж байна. | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |
| 19 | 4.22.Автозамын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэнэ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалттай уялдуулан ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүртгэж эхэлсэн. Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна | Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна. | Хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн зөрүү гаргахгүй, мөн хилийн хяналтын байгууллагуудын давхардсан шалгалтыг багасгаж, хяналтаа сайжруулахын тулд автозамын хилийн боомтууд дээр гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулахаар хамтран ажиллаж байна. Дээрх ажлыг хэрэгжүүлэхээр ХХЕГ-ын Холбоо, мэдээллийн технологийн аюулгүй байдлын газартай хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, гаалийн байгууллагаас:<br>1.тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг танайд өгөгдөл дамжуулах байдлаар илгээж, танай байгууллагаас тухайн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нарын тодорхой мэдээллийг хүлээн авах; | 2024.01.01 - 2024.06.30 | 98% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2.хилээр түр хугацаагаар тээврийн хэрэгсэл оруулсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн хилээр гарах үед нь түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэлийг шалгаж, нягтлах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>Дээрх ажлын хүрээнд ХХЕГ-т:<br>- trnspNo-тээврийн хэрэгслийн дугаар<br>- borderEntryDate-хил нэвтрэх огноо<br>- direction-экспорт<br>- registerNo-системийн дугаар<br>- trnspRfid-RFID дугаар<br>-prgsStatusCd,prgsStatusNm-Гааль зөвшөөрөв сервис мэдээллийг хүргүүлсэн. | | |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Монгол бичгийн түвшинг сайжруулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Анхан шатны мэдлэгтэй. | Дүрмээ сайжруулах | БСШУЯ, МУИС-аас хамтран хэрэгжүүлж youtube сайтаар нийт хэрэглэгчдэд зориулсан МУ-ын Ардын багш, Төрийн шагналт, хэл шинжлэлийн ухааны доктор, МУИС-ийн профессор Ш.Чоймаа багшийн “Монгол бичгийн цахим сурах бичиг” хичээлийн 1-р бүлгийн хичээлийн бүрэн үзэж дуусгав. | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | 100% |
| 2 | Гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалт, семинарт оролцох | - Хэрэгжилт, гүйцэтгэлээр<br>- Сургалтын тоогоор | Сургалт, семнарит оролцсон. | Бодлого хэрэгжүүлэх чиглэлээр оролцсон байна | Тайлант хугацаанд нийт 50 орчим уулзалт, семинари, сургалтад гаалийн байгууллагын байр суурийг илэрхийлэн оролцсон байна. Үүнд:<br>- Гаалийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгт хамаарах асуудлаар байр суурьа илэрхийлэх зорилгоор телевизийн 3 нэвтрүүлэг; | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Төр болон хувийн хэвшлийг бэхжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны 7 уулзалт, сургалт;<br>- Гаалийн хяналт шалгалттай холбоотой асуудлаар гаалийн байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийн асуудлаар 12 уулзалт, сургалт;<br>- Гаалийн байгууллагын оролцсон ажлын хэсгийн 5 уулзалт;<br>- МУЗГ, УИХТГ, ЭТГ, УОК, Олон улсын байгууллагаас зарлан хуралдуулсан 11 арга хэмжээ, уулзалт;<br>- Гаалийн байгууллагын өдөр дутмын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж чиглэлээр хангах зорилгоор нийт 12 уулзалтыг тус тус хийж, оролцсон байна. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ................................. / Г.ЭНХТАЙВАН / ......... ......... .........

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЭНХТАЙВАНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

## 1.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 66,9 |

## 2.Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Монгол бичгийн түвшинг сайжруулах | | 15 |
| 2 | Гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалт, семинарт оролцох | | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 15 |

## 3.Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 10 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 10 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 10 |
| 4 | Манлайлах | 10 |
| 5 | Багаар ажиллах | 5 |
| 6 | Харилцаа | 10 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | 9 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо:** | | 9 |

## 4.Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 66.9 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний | 15 |

| | | |
|---|---|---|
| | биелэлт | |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 9,1 |
| 4 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 91,0 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч:**

Гаалийн ерөнхий газрын дарга ............ (Р.Отгонжаргал)

............................ (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** **Нэгжийн дарга:**

Гаалийн ерөнхий газрын дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ............ (Г.Энхтайван)

............................ (огноо)